### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,968.8 сая төгрөг болж 189.1 сая төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	381.3	490.6	109.3

Авлага	154.3	133.0	-21.3
Бараа материал	90.9	93.6	2.7
Үндсэн хөрөнгө	3,153.1	3,116.3	-36.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,779.6</b>	<b>3,968.8</b>	<b>189.2</b>
Өр төлбөр	91.0	197.9	106.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,688.6	3,770.8	82.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,779.6</b>	<b>3,968.8</b>	<b>189.2</b>

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 490.6 сая төгрөг болж, өмнөх оноос 109.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	381.3	490.6	109.3
Төгрөг	381.3	490.6	109.3
Төрийн сангийн харилцах	381.3	490.6	109.3
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
<b>Дүн</b>	<b>381.3</b>	<b>490.6</b>	<b>109.3</b>

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 490.6 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 138.5 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 263.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 89.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 133.0 сая төгрөг болж, өмнөх оноос 21.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага			
Хувь хүмүүсээс авах авлага	10.7	10.7	0.0
Зээлийн авлага	143.6	122.3	-21.3
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага			
<b>Дүн</b>	<b>154.3</b>	<b>133.0</b>	<b>-21.3</b>

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын үлдэгдэл буурахад хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага буурсан нь голчлон нөлөөлжээ.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 93.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	-	-	-
Тусгай зориулалттай материал	-	-	-
Эм боох материал	-	-	-
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	-	-	-
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	-	-	-
<b>Хангамжийн материал</b>			
Бичиг хэргийн материал	3.2	4.2	1.0
Аж ахуйн материал	83.1	84.8	1.7
Сэлбэг хэрэгсэл			
Түлш, шатах тослох материал	0.0	0.0	0.0
Барилгын засварын материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	0.0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	0.6	0.6	0.0
<b>Мал амьтад</b>	<b>4.0</b>	<b>4.0</b>	<b>0.0</b>
<b>Дүн</b>	<b>90.9</b>	<b>93.6</b>	<b>2.7</b>

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэл өссөн нь бичиг хэргийн материал болон аж ахуйн бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,116.3 сая төгрөг болж, өмнөх оноос 36.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Барилга, байгууламж, орон сууц</b>	<b>2,885.7</b>	<b>2,904.9</b>	<b>19.2</b>
Хуримтлагдсан элэгдэл	-840.3	-913.7	-73.4
Авто тээврийн хэрэгсэл	424.7	692.5	267.8
Хуримтлагдсан элэгдэл	-199.9	-347.9	-148.0
Машин тоног төхөөрөмж (компьютер)	590.2	645.9	55.7
Хуримтлагдсан элэгдэл	-253.7	-325.8	-72.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	179.2	198	18.8
Хуримтлагдсан элэгдэл	-51.6	-78.4	-26.8
Зам, гүүрийн байгууламж	480.8	495.7	14.9
Хуримтлагдсан элэгдэл	-163.1	-252.3	-89.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0	0	0.0
Дуусаагүй барилга байгууламж	0	0	0.0
Номын фонд	0	0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	95.4	95.4	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-22.5	-29.3	-6.8
Программ хангамж	1.9	6.9	5.0
Хуримтлагдсан элэгдэл	-1.9	-2.4	-0.5
Бусад биет бус хөрөнгө	45.7	44.2	-1.5
Хуримтлагдсан элэгдэл	-17.4	-17.4	0.0
<b>Дүн</b>	<b>3,153.1</b>	<b>3,116.3</b>	<b>-36.9</b>

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,116.3 сая төгрөг болж 36.9 сая төгрөгөөр буурахад ЗДТГ-ын хөрөнгө буурсан нь голчлон нөлөөлсөн байна. Тайлант онд худалдаж авсан хөрөнгө 45.0 сая, хандив тусламжаар 106.5 сая, бусад эх үүсвэрээс 34.8 сая, шилжүүлэн авсан 228.4 сая, нийт 414.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, байгууллагын данс хооронд 1.6 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж, 2.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж, 31.2 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 197.9 сая төгрөг болж, өмнөх оноос 106.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилтнуудтай холбоотой өглөг	9.9	16.2	6.3
Байгууллагад төлөх өглөг	18.5	104.5	86.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	58.3	34.6	-23.7
Хувь хүмүүст төлөх өглөг	4.3	42.6	38.3
<b>Дүн</b>	<b>91.0</b>	<b>197.9</b>	<b>106.9</b>

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 197.9 сая төгрөг болж 106.9 сая төгрөгөөр өссөн нь төрийн сангийн гүйлгээний эрх хязгаарласантай холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын санхүүжилтийг бүрэн олгоогүй мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цалингийн сан хүрэхгүй байснаас өр нэмэгдсэн байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,770.8 сая төгрөг болж, өмнөх оноос 82.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	751.5	751.5	0.00
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,760.7</b>	<b>2,842.9</b>	<b>82.2</b>
Өмнөх үеийн үр дүн			
Тайлант үеийн үр дүн			
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176.4	176.4	0.00
<b>Дүн</b>	<b>3,688.6</b>	<b>3,770.8</b>	<b>82.2</b>

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,770.8 сая төгрөг болж 82.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.4.7 Орлогын данс

Бөхмөрөн сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн сумын төсөв тодотгон батлах тухай 05/02 дугаар тогтоолоор Бөхмөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 874.3 сая төгрөгийн орлого сумын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 956.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 82.0 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар давуулан

биелүүлсэн байна.

### 3.4.8 Зардлын данс

Нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 0.2 сая төгрөгийн 1 алдаа, 15.6 сая төгрөгийн 4 зөрчил илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

#### Бөхмөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:

- Бөхмөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нэг албан хаагчид 0.2 сая төгрөгийн цалинг дутуу олгож өглөгөөр бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт " Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь заалтад "Бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн тул санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж залруулга хийлгэсэн.

#### Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар:

- Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь цалингийн зардлаас тухайн албан хаагчийн ажил үүрэгт хамааралгүй ажлын үр дүнг үнэлж Бөхмөрөн сумын засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар төрийн сангийн мэргэжилтэнд санхүүгийн аудитын шалгалтаар "зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж 1.3 сая төгрөгийн урамшуулалт цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь заалтад "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байсан тул төлбөрийн акт тогтоосон.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжаар Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчдэд бэлгийн багц худалдан авахад төсвөөс 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, нь "Хөх тэнгэрийн эсгий туургатан" НҮТББ-д сумын түүх, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай нэвтрүүлэг хийхэд зориулж Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/13 тушаалаар 3.0 сая, А/15 дугаар тушаалаар 1.0 сая, МБСТВ ХХК-д 2025 оны А/06 дугаар тушаалаар 1.5 сая, нийт 5.5 сая төгрөгийг зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.1.5 дахь заалтад "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" 15.1.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг

санхүүжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байсан тул 2 албан шаардлага өгсөн.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,709.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,709.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,709.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,699.7 сая төгрөгийг урсгал зардалд, 932.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 80.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 05/02 дугаар тогтоолоор нийт зардлыг 482.3 сая төгрөгөөр бууруулан төсөвт тодотгол хийсэн байна.

Нийт зардлын 439.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,578.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 25.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 208.8 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 313.5 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,517.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 30.3 сая төгрөгийг үндсэн ажиллагааны орлогоос, нийт 1,860.6 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,292.3 сая төгрөг буюу 83.5 хувьтай байна.

#### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн:

Хүснэгт 8.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл		Нийт дүн
		Бөхмөрөн ИТХ	Бөхмөрөн ЗДТГ	
1	Программ хангамжийн бүртгэл	2.0	4.9	6.1
2	Унаа, хоолны зардал	0.0	0.0	0.0
3	Сургалт, семинар	0.0	18.0	18.0
4	Гадаад томиллолт, арга хэмжээ	0.0	0.0	0.0
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	0.0
6	Хэвлэл мэдээлэл	0.0	5.5	5.5
7	Орон тоо	3	24	27

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 83.5 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4.1 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5.0 сая, нийт 92.6 сая төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бөхмөрөн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2025 онд харьцуулалтын аргаар 6, шууд худалдан авалт 19 нийт 25 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

Д/д	ТШ код	Тендер шалгаруулалтын нэр	ТШ төрөл	Төсөвт өртөг	Тухайн оны санхүүжих өртөг	ХАА-д мөрдөх журам	Тендер зарлах огноо
1	УВАБӨСЗДТГ/ 20250202026	Малчдад зориулсан мал ариутгалын дук машин авах	Бараа	60,000,000 ₮	60,000,000 ₮	Харьцуулалтын арга	6/16/2025
2	УВАБӨСЗДТГ/ 20250202003	Хүүхдийн цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж	Бараа	30,500,000 ₮	30,500,000 ₮	Харьцуулалтын арга	2/20/2025
3	УВАБӨСЗДТГ/ 20250602001	Эрүүл мэндийн төвд биохими памп шахуургын аппарат авах	Бараа	11,000,000 ₮	11,000,000 ₮	Шууд худалдан авалт	11/11/2025
4	УВАБӨСЗДТГ/ 20250602002	Хүүхдийн цэцэрлэгт сургалтын ухаалаг самбар	Бараа	11,000,000 ₮	11,000,000 ₮	Шууд худалдан авалт	9/5/2025
5	УВАБӨСЗДТГ/ 20250602008	Сумын төвийг ногоон бүс болгох хяналтын камер нэмэх	Бараа	15,000,000 ₮	15,000,000 ₮	Шууд худалдан авалт	11/20/2025
6	УВАБӨСЗДТГ/ 20250203028	Сумын дэд бүтцийн шугам сүлжээ зураг төсөв	Үйлчилгээ	50,000,000 ₮	50,000,000 ₮	Харьцуулалтын арга	1/20/2025
7	УВАБӨСЗДТГ/ 20250203006	Сумын нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх	Үйлчилгээ	50,000,000 ₮	50,000,000 ₮	Харьцуулалтын арга	3/5/2025
8	УВАБӨСЗДТГ/ 20250201025	Мал нядалгааны нэгдсэн цэг байгуулах	Ажил	50,000,000 ₮	50,000,000 ₮	Харьцуулалтын арга	5/12/2025
9	УВАБӨСЗДТГ/ 20250602016	Сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх /тэжээл /	Бараа	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
10	УВАБӨСЗДТГ/ 20250602015	Сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх /Өвс /	Бараа	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
11	УВАБӨСЗДТГ/ 20250602010	Төрийн албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Бараа	10,000,000 ₮	10,000,000 ₮	Шууд худалдан авалт	9/22/2025
12	УВАБӨСЗДТГ/ 20250602034	Байшинт багийн аюулгүйн нөөц бүрдүүлэх /Тэжээл /	Бараа	15,000,000 ₮	15,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
13	УВАБӨСЗДТГ/ 20250601033	Сумын төвийн хороололд эко нойд байрлуулах зардал	Ажил	5,000,000 ₮	5,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/11/2025
14	УВАБӨСЗДТГ/ 20250602009	Иргэний танхимд шаардлагатай тоног төхөөрөмж тохижуулалт хийх	Бараа	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	3/3/2025
15	УВАБӨСЗДТГ/ 20250601032	Ачит нуур дэвсгэрийн арлын жилийн зурвас багана барих	Ажил	5,000,000 ₮	5,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/25/2025
16	УВАБӨСЗДТГ/ 20250601031	Хиллийн цэргийн 227-р салбарын автомашины гراج барих	Ажил	10,550,000 ₮	10,550,000 ₮	Шууд худалдан авалт	8/25/2025
17	УВАБӨСЗДТГ/ 20250601023	Булгын эхний гүүр засвар үйлчилгээ	Ажил	15,000,000 ₮	15,000,000 ₮	Шууд худалдан авалт	6/16/2025
18	УВАБӨСЗДТГ/ 20250601022	Гурван жигэртэй багийн конторын тохижилт	Ажил	5,000,000 ₮	5,000,000 ₮	Шууд худалдан авалт	5/1/2025
19	УВАБӨСЗДТГ/ 20250602021	Гурван жигэртэй багийн аюулгүйн нөөц бүрдүүлэх /тэжээл/	Бараа	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
20	УВАБӨСЗДТГ/ 20250602020	Гурван жигэртэй багийн аюулгүйн нөөц бүрдүүлэх /өвс/	Бараа	15,000,000 ₮	15,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
21	УВАБӨСЗДТГ/ 20250602019	Хар Алтат багийн аюулгүйн нөөц бүрдүүлэх /тэжээл/	Бараа	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
22	УВАБӨСЗДТГ/ 20250602018	Хар Алтат багийн аюулгүйн нөөц бүрдүүлэх /өвс/	Бараа	15,000,000 ₮	15,000,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
23	УВАБӨСЗДТГ/ 20250601017	Хар Алтат багийн конторын халаалт	Ажил	5,000,000 ₮	5,000,000 ₮	Шууд худалдан авалт	10/1/2025
24	УВАБӨСЗДТГ/ 20250602035	Байшинт багийн аюулгүйн нөөц бүрдүүлэх /Өвс/	Бараа	12,279,000 ₮	12,279,000 ₮	Шууд худалдан авалт	8/18/2025
25	УВАБӨСЗДТГ/ 20250202005	Сургуулийн ангилуудын ширээ сандал шинэчлэх	Бараа	90,000,000 ₮	90,000,000 ₮	Харьцуулалтын арга	

Тайлант онд огт хэрэгжээгүй 1 төсөл арга хэмжээ, дутуу хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээ, төрийн сангийн зарлагын гүйлгээг хязгаарласантай холбоотой санхүүжилт дутуу олгосон 9 төсөл арга хэмжээ байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,951.5 сая төгрөгийн 1 хувиар буюу 19.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,949.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 19.5 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 15.6 сая төгрөгөөр тогтоосон.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 230.5 сая төгрөгийн 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 275.0 сая төгрөгийн 6 гүйлгээг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 259.1 сая төгрөгийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 259.3 сая төгрөгийн 32 шийдвэр, батлагдсан төсвийг байршуулаагүй, тайлант хугацаанд 6 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ. Үүнд :

Бөхмөрөн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 137.3 сая төгрөгийг төсөвт өртөгтэй өвс, тэжээлийн нөөц бэлтгэх төсөл арга хэмжээг сумын болон багийн гэж 4 хуваан төлөвлөн шууд худалдан авалт арга ашиглан гүйцэтгэгчийг шалгаруулан худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 дах заалтад "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүйд зөвлөмж өглөө.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага өгснийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 200 дугаар албан бичгээр биелэлтийг тайлагнан санхүүгийн аудитын [fas.audit.mn](http://fas.audit.mn) цахим системд байршуулсан байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар баталсан ч сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/05 дугаар захирамжаар тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа орон тоонд байхгүй сантехнич, олон нийтийн цагдаа, хөдөөгийн 2 багийн сахиулын орон тоог батлан ажиллаж байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

#### 4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 1 төсвийн байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгч, 1 төсвийн байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 15.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 0.2 сая төгрөгийн зөрчилд залруулга хийж, 8.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 1.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөрчилд 2 албан шаардлага өглөө.

#### Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 9.

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	4	15.8			1	1.3	2	6.0	1	8.3
2	ИТХ	1	0.2	1	0.2						
		5	15.8	1	0.2	1	1.3	2	6.0	1	8.3

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,161.2 сая төгрөгийн нийцлийн аудитын асуудлын зөрчил илэрснээс 1,023.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 137.3 сая төгрөгийн 1 зөрчил зөвлөмж өглөө.

##### 5.2 Албан шаардлага

Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 230.5 сая төгрөгийн 4 мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 275.0 сая төгрөгийн 6 гүйлгээг, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 259.1 сая төгрөгийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 259.3 сая төгрөгийн 32 шийдвэр, батлагдсан төсвийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.3 дахь заалтад “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад



**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бөхмөрөн сум	1	1,023.9			1	1,023.9		
Дүн	1	1,023.9			1	1,023.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бөхмөрөн сум	1	137.3					1	137.3
Дүн	1	137.3					1	137.3
Нийт дүн	1	1,161.2			1	1,023.9	1	137.3

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

~~АУДИТЫН ТАЙЛАН~~

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



БАТСУУРЬ/

БАТ-АМГАЛАН/

Т.АМАРМЭНД/

2026 оны 03 сарын 24-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 01/54/А 2070413  
УВА-2026/008/НА-СТА-ТБ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 230.5 сая төгрөгийн 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 275.0 сая төгрөгийн 6 гүйлгээг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 259.1 сая төгрөгийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 259.3 сая төгрөгийн 32 шийдвэр, байгууллагын батлагдсан төсвийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 дахь заалтад "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.3 дахь заалтад "Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь заалтад "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөхмөрөн сумын Засаг дарга П.Баярсайхан, Санхүү албаны дарга Н.Заяахүү, Нягтлан бодогч Х.Саруул-Эрдэнэ нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.АМАРМЭНД

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ